



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

「Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/2583 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэлийг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс томилсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



ХЭРЭГ
ХАМГАА